Сувилагчдын сэтгэл гутрал, айдас түгшүүр, стрессийг судалсан нь

Д.Цэвээнжав[1], Ж.Мөнхханд[1], Г.Сүхбат[2], Г.Ганхуяг[1]

[1]АШУҮИС, Сувилахуйн сургууль
[2]АШУҮИС, Био-АС
Цахим шуудан: Tseveenee_0119@yahoo.com, Утас: 89090821

Түлхүүр үг:

Сувилагч
Сэтгэл гутрал
Айдас түгшүүр
Стресс
Хамаарал

Товч утга:

Үндэслэл: Сувилагч нар эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулахад их үүрэг гүйцэтгэдэг, эрүүл мэндийн салбарын чухал гишүүн билээ. Тэд ээлжийн ажил хийх, эмнэлзүйн гардан үйлдэл хийх, яаралтай тусламж үзүүлэх, өвтөнийг нас барах үед нь дэргэд нь байх зэргээр хүний эрүүл мэндийн төлөө хариуцлагатай ажилладаг. **Зорилго:** Сувилагчдын сэтгэл гутрал, айдас түгшүүрийг судлах. **Арга, аргачлал:** Нэг агшингийн дескриптив судалгааны загварыг ашигласан. Нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа 8 дүүргийн эрүүл мэндийн төв болон нэгдсэн эмнэлэгт ажилладаг 360 сувилагчийг санамсаргүй түүврийн аргаар түүвэрлэн авсан. Хүн амзүйн 9 асуумж болон сэтгэл гутрал, айдас түгшүүр, стрессийг үнэлэх 42 нийт 2 бүлэг, 51 асуумжаар судалгаа авсан. Судалгааны боловсруулалтыг SPSS-22 программын хи квадрат, Пирсоны корреляци ашиглан хийсэн. **Үр дүн:** Сувилагч нарын сэтгэл гутрал, айдас түгшүүр, стрессийн түвшин: хэвийн 64.4%, 44.2%, 77.8%; сул 15%, 10.0%, 10.8%; дунд зэрэг 15.6%, 24.2%, 8.9%; хүнд 3.6%, 13.6%, 1.9%; маш хүнд 1.4%, 8.1%, 1.6% байв. Сэтгэл гутрал, айдас түгшүүр, стресст ээлжийн сувилагч илүү өртөж байна. Сэтгэл гутрал, айдас түгшүүр, стрессийн хооронд хамааралыг судлаж үзэхэд: сэтгэл гутрал, айдас түгшүүр хооронд өндөр хамааралтай ($r=0.718$, $p<0.01$) байв. Сэтгэл гутрал, стрессийн хооронд статистикийн үнэн магадлалтай өндөр хамаарал ажиглагдсан ($r=0.765$, $p<0.01$).

Үндэслэл: Дэлхий дээр 2020 оны байдлаар 264 сая гаруй хүн сэтгэл гутралтай байгаагаас хүйсийн хувьд эмэгтэйчүүд эрчүүдээсээ илүүтэй сэтгэл гутралд нэрвэгдэж байгааг онцолжээ. Өнөөгийн байдлаар дэлхийн 4 хүн тутмын 1 нь сэтгэцийн ямар нэгэн эмгэгт нэрвэгдэж байгаагаас гадна хөдөлмөрийн чадвар алдалтанд хүргэдэг 10 өвчний 5 нь сэтгэцийн эмгэг байна[1].

Эмнэлзүйн орчинд ажиллаж буй бусад мэргэжилтэнгүүдээс, мөн нийгэм, хамт олны дундаас ч сувилагч хүн сэтгэлзүйн дарамт, сэтгэцийн эмгэгт нэрвэгддэг талаар сувилагчдын сэтгэл гутрал, айдас, стрессийн түвшинг үнэлсэн судалгаануудаар нотолжээ[2,3].

Ажлын өндөр ачаалал, ээлжийн ажил нь сувилагчдын хувьд сэтгэл гутралд орох, айдас, стресст автах суурь хүчин зүйлүүдийн нэг болж байна. Сэтгэцийн нэг болоод түүнээс дээш эмгэг нь ажилдаа дургүй болох сөрөг мэдрэмж, хандлагыг төрүүлээд зогсохгүй цаашлаад ажлын байран дээр мэргэжлийн алдаа гаргах нөхцөлийг бүрдүүлэх аюултай юм. Иймд сувилагчдын сэтгэл гутрал, айдас, стрессийг илрүүлэх, үнэлэх асуудалд анхааран сэтгэл судлалын судалгаануудыг эрчимтэй хийж эхэлж байна[4,5,6].

Сувилагчийн сэтгэл гутрал, айдас түгшүүр, стресс нь сувилахуйн тусламж үйлчилгээг чанартай үзүүлэхэд нөлөөлдөг болохыг тогтоосон судалгааг Tran /2019/ нар Вьетнамын сувилагчдын сэтгэл гутрал, айдас, стрессийг үнэлсэн судалгаанд дурьдсан байна[7].

2019 оны байдлаар Улаанбаатар хотын дүүргийн нэгдсэн эмнэлэг, нийгмийн эрүүл мэндийн төвүүдэд 895 их эмч, 988 сувилагч, нийтдээ 3481 эмч, эмнэлгийн ажилчид байна[8]. Эрүүл мэндийн статистик мэдээгээр сэтгэц, зан үйлийн эмгэгийн тохиолдол 2000 онд 10000 хүн амд 77.4 байсан бол 2019 онд 114.3 болж нэмэгджээ[9].

Нийгэм, эдийн засгийн байдал, шинжлэх ухаан, техник, технологи, мэдээллийн салбарт гарч

буй эрс өөрчлөлт, хотжилт, хүн амын хэт төвлөрөл зэрэг олон талт нөхцөл байдлуудын нөлөөллөөс сүүлийн жилүүдэд иргэдийн дунд сэтгэл санааны хувьд тогтворгүй болох, зовних, айх, түгших, гутрах зэрэг сөрөг сэтгэл хөдлөлүүд ажиглагдах боллоо. Үйлчлүүлэгчтэй хамгийн ойр харилцдаг сувилагч нарын хувьд сэтгэл гутрал, айдас түгшүүрийг судлах зорилгоор энэхүү сэдвийг сонгосон болно.

Зорилго: Сувилагчдын сэтгэл гутрал, айдас түгшүүрийг судлах.

Зорилт:

1. Сувилагчийн сэтгэл гутрал, айдас, түгшүүрийн түвшинг тодорхойлох
2. Сувилагч нарын сэтгэл гутрал, айдас, стрессийн түвшинг албан тушаалтай холбон судлах
3. Сэтгэл гутрал, айдас түгшүүр, стрессийн хоорондын хамааралыг судлах

Арга, аргачлал: Нэг агшингийн асуумж судалгааны аргыг ашиглан сувилагчийн сэтгэл гутрал, айдас, түгшүүрийг Австралийн Шинэ Өмнөд Уэльсийн Их Сургуулийн боловсруулсан Сэтгэл гутрал, айдас түгшүүр, стрессийг үнэлэх (DASS) асуулгаар судалгааг хийсэн .

Оноог тооцох: Сэтгэл гутрал, айдас, стрессийн оноог өөр хоорондоо холбоотой асуултуудын оноог нэмж тооцдог.

- ✓ Сэтгэл гутралын хэмжүүрийн асуултуудад 3, 5, 10, 13, 16, 17, 21, 24, 26, 31, 34, 37, 38, 42 орно.
- ✓ Айдсын асуултууд нь 2, 4, 7, 9, 15, 19, 20, 23, 25, 28, 30, 36, 40, 41 болно.
- ✓ Стрессийн асуултууд 1, 6, 8, 11, 12, 14, 18, 22, 27, 29, 32, 33, 35, 39 юм.

Асуултанд хариулсан хүн тус бүрийн оноог хүндрэлийн зэргээр нь доорх индексээр тооцсон (хүснэгт 1).

Хүснэгт 1. Хүндрэлийн зэргийг тодорхойлох индекс

Хүндийн зэрэг	Сэтгэл гутрал	Айдас	Стресс
Хэвийн	0-9	0-7	0-14
Сул	10-13	8-9	15-18
Дунд зэрэг	14-20	10-14	19-25
Хүнд	21-27	15-19	26-33
Маш хүнд	28+	20+	34+

Судалгааны статистик боловсруулалтыг SPSS-22 программ дээр хи квадрат, Пирсоны корреляци ашиглан гүйцэтгэсэн.


Судалгааны хамрах хүрээ: Нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа 8 дүүргийн эрүүл мэндийн төв болон нэгдсэн эмнэлэгт ажилладаг 360 сувилагчийг санамсаргүй түүврийн аргаар түүвэрлэн авч 2 бүлэг, 51 асуумжаар судалгаа авсан.

Үр дүн: Судалгаанд хамрагдсан нийт сувилагчид боловсролын хувьд 45% нь диплом, 51.4% нь бакалавр, 3.6% нь магистр зэрэгтэй байв. Судалгаанд хамрагдсан сувилагчдын 35.6% сэтгэл гутралтай, 55.8% нь айдас түгшүүртэй, 22.2% стресстэй байна (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Сувилагчдын сэтгэл гутрал, айдас түгшүүр, стрессийн түвшин /хувиар/

Хүндийн зэрэг	Тоо, хувь	Сэтгэл гутрал	Айдас түгшүүр	Стресс
Хэвийн	Тоо	232	159	280
	Хувь	64.4%	44.2%	77.8%
Сул	Тоо	54	36	39
	Хувь	15%	10.0%	10.8%
Дунд зэрэг	Тоо	56	87	32
	Хувь	15.6%	24.2%	8.9%
Хүнд	Тоо	13	49	7
	Хувь	3.6%	13.6%	1.9%
Маш хүнд	Тоо	5	29	2
	Хувь	1.4%	8.1%	0.6%
Нийт	Тоо	360	360	360
	Хувь	100%	100%	100%

Сувилагчдын сэтгэл гутрал, айдас түгшүүр, стрессийг албан тушаалтай холбон судлахад дараах үр дүн гарсан.



Зураг 1. Сэтгэл гутрал, айдас түгшүүр, стрессийг албан тушаалаар харьцуулсан байдал

Сэтгэл гутрал, айдас түгшүүр, стресст ээлжийн сувилагч харьцангуй илүү өртөж байна (Зураг 1).

Сэтгэл гутрал, айдас түгшүүр, стрессийн хоорондын хамааралыг судлаж үзэхэд: сэтгэл гутрал, айдас түгшүүр хооронд өндөр хамааралтай ($r=0.718$, $p<0.01$) байв. Сэтгэл гутрал, стрессийн хооронд статистикийн үнэн магадлалтай өндөр хамаарал ажиглагдсан ($r=0.765$, $p<0.01$).

Хэлцэмж: Бидний судалгаагаар сувилагч нарын 33.6% нь сэтгэл гутралтай, 55.8% нь айдас түгшүүртэй, 22.2% нь стресстэй байсан. Tran TTT (2019) нарын хийсэн судалгаагаар сэтгэл гутралтай 18.5%, айдас түгшүүр 39.8%, стресс 13.2% байгаа нь бидний судалгааны үр дүнгээс бага үзүүлэлттэй байна. Ruisan Sun (2021) нарын хийсэн судалгаагаар сувилагч нарын 61.3% нь стресстэй байсан нь бидний судалгааны үр дүнгээс харьцангуй өндөр үзүүлэлттэй гарсан байна[13]. Бидний

судалгаагаар стрессийг зэргээр авч үзэхэд: стрессгүй 77.8%, стресс сул зэрэгтэй 10.8%, дунд зэрэгтэй 8.9%, хүнд зэрэгтэй 2.5% байсан. Ruisan Sun нарын судалгаанд эмнэлгийн ажилчдын дунд стрессийн зэргээр авч үзэхэд 57.5% стрессгүй, сул зэрэгтэй 17.8%, дунд зэрэг 15.1%, хүнд зэрэг 9.6% байгаа нь бидний судалгааны үр дүнтэй харьцуулахад бага байна.

Дүгнэлт:

1. Сувилагч нарын дунд айдас түгшүүр нь сэтгэл гутрал, стрессээс харьцангуй их тохиолдож байна.
2. Сэтгэл гутрал, айдас түгшүүр, стресст ээлжийн сувилагч илүү өртөж байна.
3. Сэтгэл гутрал нь айдас түгшүүр болон стресстэй өндөр хамааралтай байна. Энэ нь стресс, айдас түгшүүрийг тухайн үед нь тайлахгүй удаан үргэлжилбэл сэтгэл гутрал үүсэх өндөр эрсдэлтэй байгааг харуулж байна.

Талархал: Энэхүү судалгааг авахад хамтран ажилласан Нийслэлийн Эрүүл мэндийн газрын сувилахуй хариуцсан мэргэжилтэн Ц.Сонгиносүрэн болон Нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа Дүүргийн эрүүл мэндийн төвүүд, Нэгдсэн эмнэлгүүдийн Сувилахуйн албадын дарга нарт гүн талархал илэрхийлье. Судалгаанд оролцсон дүүргийн эрүүл мэндийн төвийн болон нэгдсэн эмнэлгийн нийт сувилагч нартаа талархал илэрхийлье.

Ном зүй:

1. *World Health report, 2020. https://www.who.int/news-room/fact-sheets/detail/depression*
2. *Cheung T, Yip PSF. Depression, Anxiety and Symptoms of Stress among Hong Kong Nurses: A Cross-sectional Study. International Journal of Environmental Research and Public Health. 2015;12(9):11072-11100.*
3. *Roustaei N, Jafari P, Jafari P, Sadeghi E, Jamali J. Evaluation of the Relationship between Social Desirability and Minor Psychiatric Disorders among Nurses in Southern Iran: A Robust Regression Approach. Int J Community Based Nurs Midwifery. 2015/10// 2015;3(4):301-308.*
4. *Suzuki K, Ohida T, Kaneita Y, et al. Mental health status, shift work, and occupational accidents among hospital nurses in Japan. Journal of occupational health. Nov 2004;46(6):448-454.*
5. *Kawano Y. Association of job-related stress factors with psychological and somatic symptoms among Japanese hospital nurses: effect of departmental environment in acute care hospitals. Journal of occupational health. 2008;50(1):79-85.*
6. *Welsh D. Predictors of Depressive Symptoms in Female Medical-Surgical Hospital Nurses. Issues in Mental Health Nursing. 2009/01/01 2009;30(5):320-326.*
7. *Tran TTT, Nguyen NB, Luong MA, et al. Stress, anxiety and depression in clinical nurses in Vietnam: a cross-sectional survey and cluster analysis. International Journal of Mental Health Systems. 2019/01/03 2019;13(1):3.*
8. *ЭМХТ, Эрүүл мэндийн үзүүлэлт. УБ. 2019 он х-86*
9. *"Сэтгэцийн эрүүл мэнд" үндэсний хоёр дахь хөтөлбөр. УБ хот. 2019 он*
10. *Otgonbaatar D, Ts L, Ariunaa D, Tundevrentsen A, Naranbaatar N, Munkhkhand J. Occupational stress in nurse sAA—the study provided during the urged pandemic COVID-19 quarantine period. Psychology. 2020;11(05):704.*
11. *Dondonkhuu O, Enkhbayar M, Nyam N, Jurmeddorj M. Exposing the changes in work stress level among Mongolian nurses by salivary Alpha amylase test. Proceedings of the Mongolian Academy of Sciences. 2020:32-38.*
12. *Базаррагчаа С. Амь тэнссэн өвчтөнтэй тасгийн эмч, сувилагч нарын нийгэм-сэтгэлзүйн асуудал. АУ-ны докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл 2020 он*
13. *Ruisan Sun, Cailin Zhang, Keyao Lv, Yajia Lan. Identifying the risk features for occupational stress in medical workers: a cross sectional study. 2021*

Research depression and anxiety of nursing

Tseveenjav D[1], Munkhkhand J[1], Sukhbat G[2], Gankhuyag G[1]

[1]School of Nursing, MNUMS
[2]School of Bio-Medicine, MNUMS
E-mail: Tseveenee_0119@yahoo.com, Tel: 89090821

Background Nurses are important members of the health sector; they play a many role in improving the quality of health care. They having responsibility for human health, shift works, performing clinical procedures, to be near patients when dying, provide emergency assistance.

Aim: The aim of this study was to determine depression, anxiety and stress among nurses.

Materials and Methods: This present study was a descriptive-analytic and cross-sectional study, which was conducted on 360 nurses working in health center and hospital of Ulan-Bator 8 districts, using stratified random sampling. The research instruments included 2 groups, 51 item: demographic questionnaire and depression, anxiety and stress questionnaire (Depression Anxiety, Stress, Scale-DASS-42)

Data was analyzed using chi square, Pearson's correlation of SPSS-22 programm.

Conclusion:

1. Anxiety was more common among nurses than depression and stress.
2. Nurses on duty are more prone to depression, anxiety and stress.
3. Depression is highly correlated with anxiety and stress. This suggests that there is a high risk of depression if stress and anxiety persists for a long time.

Keywords: Nurse, depression, anxiety, stress, correlation